



**ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Компанийн удирдлага, зохион байгуулалтын
бүтцийг шинэчлэн байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний тухай хуулийн 2015 оны нэмэлт өөрчлөлтийн хүрээнд компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсны дагуу Удирдлага, санхүүгийн албыг 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс болгож шинэчлэн байгуулсугай.

2. Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс болон Арилжааны зохицуулалтын албаны үйл ажиллагаанд хяналт тавьж, шууд удирдлагаар хангаж ажиллахыг Дэд захирал /Ц.Эрдэнэбулган/-д даалгасугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Ц.Эрдэнэбулган/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ЦОГТБААТАР